

**НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН 2024 - 2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН
ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

Зорилго: Иргэд ажил, амьдралын орчинд суралцах шаардлагатай ур чадвар эзэмших, хөгжих, суралцах тэгш боломжийг бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, гадаад улсад ажиллаж амьдарч буй иргэдийн насан туршийн суралцахууд дэмжлэг үзүүлэх зорилгыг 2024-2025 оны хичээлийн жилд дэвшүүлж байна.

№	Зорилтууд	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	Иргэд ажил, амьдралын орчинд суралцах шаардлагатай ур чадвар эзэмших, хөгжих суралцахууг дэмжих	1. Иргэдээс сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгаа авч судалгаанд үндэслэн "Гар урлалын багц сургалт"-ыг Дарьганга, Сүхбаатар суманд зохион байгууллаа. Энэхүү сургалтаар иргэдийн гар урлалын олон талт мэдлэг, дадал чадвар эзэмших, хөдөлмөр эрхлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд чиглэсэн гипсэн урлал, давсан урлал, саван, үнэртүүлэгч, лаа, бэлэг дурсгал зэрэг бүтээгдэхүүн хийх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 34 иргэн хамрагдаж, сургалтын үйл ажиллагаанд 955000 төгрөг зарцуулсан байна. 2. Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ХҮМҮҮН БИЧИГ-ХҮН БҮРИЙН БИЧИГ" ур чадварын уралдааныг Сүхбаатар аймгийн Хэлний бодлогын зөвлөл, Аймгийн ЗДТГ, Насан туршийн суралцахуйн төв, Боловсролын газар, Нийтийн номын сантай хамтран 10 дахь жилдээ зохион байгууллаа. Уралдаанд 13 сумын Засаг даргын тамгын газрын нийт 75 төрийн албан хаагч оролцсон. 3. Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн чадамжийг дээшлүүлэх, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Хүмүүн бичиг" сонин захиалж, байгууллагын албан хаагчид 7 хоног бүр хичээнгүй бичиг бичиж мэдлэг чадвараа дээшлүүлж байна. 4."Мэдээлэл технологийн сургалтыг 10 төрийн байгууллагын 165 ажилтан албан хаагчдад зохион байгуулсан. 5. Бэлгийн боловсролын цогц агуулгын хүрээнд сумдын Насан туршийн суралцахуйн нэгжүүдээр дамжуулан ЕБС-ийн өсвөр насны 76 охид, хөвгүүдэд сургалт зохион байгуулсан. 6. Баруун урт сумын БНО ангийн суралцагчдын 14 эцэг эх, асран хамгаалагчдад "Суралцахуйн бэрхшээлтэй,	100%

		зан үйлийн асуудал хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулсан. 7. Төрийн үйлчилгээг цахимаар хурдан шуурхай авах зорилгоор E-Mongolia аппликейшн, Ухаалаг гар утасны хэрэглээ зэрэг хэрэгцээт сургалтыг Баруун-Урт сумын хөгжлийн бэрхшээлтэй 15 иргэнд зохион байгууллаа. 8. Баруун-Урт сумын Насан туршийн суралцахуйн багш сурагчид анги, танхимгүйн улмаас сүүлийн дөрвөн жил НТСТ-ийн байранд сургалт үйл ажиллагааг зохион байгуулж байсан. Багш, сурагчдын ажиллаж, сурч боловсрох таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Баруун-Урт сумын ЗДТГ-аас 15 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, анги танхимыг шийдвэрлэж бүрэн засвар хийсэн. 9. Насан туршийн суралцахуйн төвөөс аймгийн 13 сумын ахмадын хорооны дарга, тэргүүлэгчдэд 2025 оны үйл ажиллагааны чиглэлээ танилцуулж хамтран ажиллах боломжуудын талаар хэлэлцэж цаашид хамтран ажиллахаар төлөвлөөд байна. 10. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Бүх нийтийн англи хэлний чадварыг дээшлүүлэх хэрэгцээ тодорхойлох судалгаа боловсруулан судалгаанд 508 иргэн хамрагдлаа.	
2	Насан туршийн суралцахуйн төвийн багш, хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	Хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих чиглэлээр дараах сургалт, үйл ажиллагааг зохион байгууллаа. Насан туршийн суралцахуйн төв, нэгжийн нийт багш нарын 50% нь салбартаа 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа бөгөөд бүгд үндсэн орон тоон дээр ажилладаг. Боловсролын түвшин 16.6% нь Магистр, 78.4% нь бакалавр боловсролтой байна. 2024-2025 оны хичээлийн жилд дараах сургалтуудад хамрагдлаа. Үүнд: 1. Насан туршийн суралцахуйн төв 13 сумдын нэгжийн багш нартаа “Насанд хүрэгчдэд зориулсан мэдээлэл технологийн боловсрол”, “Цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдал, ёс зүй” сургалтад 22 багш 2. Удирдлагын академийн “Үндэсний бичгийн цахим сургалт” /цахим/ сургалтад 22 багш 3. Aplus -ийн Хүүхдийн хэлний хөгжил ба	

		харилцааны чадвар, Зөв бичих дүрмийн арга зүй, Бага насны хүүхдэд математик заах арга зүй сэдэв сургалтад 3 багш 4. Багшийн мэргэжлийг дээшлүүлэх 1,5,10 жилийн үндсэн сургалтад 3 багш 5. Насан туршийн суралцахуйг салбарын нийт багш нарыг чадавхжуулах сургалтыг "И-Монгол академи" УТҮГ-ын сургалт, олон нийттэй харилцах газар, сургалтын хэлтсийн дарга В.Лут-Очир-той хамтран "Хиймэл оюун ба багшийн ур чадвар" сургалтад 23 багш 6. ЯХИС-аас хэрэгжүүлсэн "Өсвөр үеийн хүүхэд залуучуудад хувь хүний ур чадвар энтрепренершип боловсрол олгох" төслийн ESEL хөтөлбөрийн сургалтыг Аймгийн Боловсролын газар, төслийн мастер багш нартай хамтран сум орон нутагт зохион байгуулах "Сургагч багш" нарыг бэлтгэх сургалтад 28 багш 7. Аймгийн ИТХ-ын 2025 оны "Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, нийгмийн баталгааг дээшлүүлэх жил" болгон зарлаж АЗДТГ-с зохион байгуулсан "Монголын Илтгэгчдийн Холбоо"-ны Ерөнхийлөгч, бизнес зөвлөх, хуульч Ц.Азбаярын "Харилцаа ба Ёс зүйг эрхэмлэх нь" сургалтад 4 багш 8. Илтгэх Индрийн Ирээдүй ТББ-ын үүсгэн байгуулагч, үндэсний сургагч багш Д.Хүрэлбаатарын "Та хугацааг юунд хамгийн ихээр зарцуулж байна вэ?" сургалтад 4 албан хаагч 9. Сэтгэл судлалын шинжлэх ухааны доктор А.Ирээдүй багшийн "XXI зууны иргэдийн зайлшгүй эзэмших хувь хүний хөгжлийн чадварууд", "Аз жаргалтайгаар ажлын байрандаа өөрийгөө хөгжүүлэх аргачлал" сургалтад 8 албан хаагч 10. Сүхбаатар аймгийн ЕБ 1 дүгээр сургуулийн 100 жилийн ойн ажлын хүрээнд зохион байгуулагдсан "Гавьяатуудаасаа суралцъя" уулзалт, хэлэлцүүлэгт 8 албан хаагч 11. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалт сургалтад 22 багш хамрагдсан. 2024-2025 оны хичээлийн жилд 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 229 багш, албан хаагч хамрагдсан байна. Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дараах ажлыг зохион	
--	--	---	--

		байгууллаа. 1. Насан туршийн суралцахуйн багш нарын онол арга зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, иргэдийн боловсролыг дэмжих сургалт арга зүйн онцлог, хэрэглээг түгээн дэлгэрүүлэх, сургалтын хөтөлбөрийн санг баяжуулах зорилгоор багш нарын ур чадварын уралдааныг зохион байгуулж 13 сумын 14 багш оролцсон. Уралдааны шүүгчээр Монгол улсын зөвлөх багш, ментор Сугарын Эрдэнэтуяа уригдан ажилласан. 2. 11 сарын 04-05-ний өдрүүдэд Зүүн 7 аймгийн / Хэнтий Дорнод Сүхбаатар Дорноговь Дундговь Өмнөговь Төв / насан туршийн суралцахуйн багш нарыг чадавхжуулах сургалт үйл ажиллагаанд 20 албан хаагч оролцож, Аймгийн Засаг даргын дэмжлэгээр хэрэгжсэн иргэдийн цахим ур чадварыг дэмжих “Цахимаар нэгдье” хөтөлбөр, УИХ гишүүн асан Наянтайн Ганибалын ивээн тэтгэлгээр хэрэгжсэн “Суралцагч аймаг 3*7*3” хөтөлбөр, Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох “Автобустай аялал” зэрэг үйл ажиллагааг онцлон танилцуулж түгээн дэлгэрүүллээ. Мөн Баруун-Урт сумын Насан туршийн суралцахуйн багш М.Дуламжаргал Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй өсвөр үеийн хүүхэд залуучуудыг дэмжих ESEL хөтөлбөрийн хүрээнд зүүн бүсийн нийт багш нарт сургалт зохион байгуулж туршлагаа түгээн дэлгэрүүллээ. - Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх Esel сургалтыг орон нутагтаа нутагшуулан 13 сумын дотуур байрны 7-12 дугаар ангийн 195 сурагчийг хамруулан сургалтыг түгээн дэлгэрүүлж байна.	
3	Гадаад улсад амьдарч буй иргэдэд монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг суралцахад дэмжлэг үзүүлэх	- Америкт амьдардаг бага боловсрол эзэмшиж буй хүүхэд, Монгол гэр бүл, иргэдтэй цахим хэлбэрээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж байна. Сургалтыг “Цагаан толгой”, “Монгол бахархал” гэсэн агуулгаар өдөрт 40 минутаар долоо хоногт 3 удаагийн цахим уулзалтаар тогтмол холбогдон явуулж байгаа бөгөөд 2020-2024 онуудад нийт 5 суралцагчийг монголоор уншиж бичих чадвар эзэмшүүлсэн байна. - “НАМУ” Солонгос дахь хүүхэд гэр бүл сэтгэл зүйн төвд хандаж Солонгост амьдарч буй Сүхбаатар аймгийн харьяат	

		нийт 6-13 хүртэл насны 3 хүүхдийг “Монгол хэл” сурах сургалтад хамруулж байна.	
4	Насан туршдаа суралцахуйн мэдээллийн системийг хөгжүүлж, их өгөгдлийг бий болгох	http://su-ncle.com/ Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн төв нь 2023 оноос эхлэн веб сайт ажиллуулж эхэлсэн бөгөөд салбарын бодлого, үйл ажиллагаа түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээ мэдээллийг нийтэлж сайтын хөгжүүлэлтийг тогтмол хийж байна. Мөн 13 сумын Насан туршийн суралцахуйн салбарын үйл ажиллагааг харах боломжтой.	
5	Салбар дундын түншлэлийг хөгжүүлэх, түншлэгч байгууллагууд, олон нийтийн оролцоотой хамтран суралцагч хот, суралцагч байгууллагыг бий болгоход дэмжлэг үзүүлэх	1. “Дэлхийн Мөнгөний долоо хоног-2025” аяныг Сүхбаатар аймаг дахь Монгол банк, банк санхүүгийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. Аяны хүрээнд аймгийн хэмжээнд “Мөнгөө эрсдэлээс хамгаалж, ирээдүйгээ баталгаажуулъя” сэдвээр нийт 15 удаагийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж 520 сурагч хамруулсан. ЕБС-н дунд болон ахлах бүлгийн сурагчид, МСҮТ-н сурагчдын дунд Санхүүгийн суурь боловсролын ач холбогдлыг хүүхэд, залуучуудад ойлгуулах, олон нийтэд сурталчлах зорилгоор “Санхүүгийн зөв шийдвэр, маргаашийн амжилтын эхлэл” сэдэвт богино хэмжээний видео бичлэгийн уралдаан зохион байгуулсан. Тус уралдаанд 14 бүтээл ирж 500,000 төгрөг зарцуулсан. 2. Сүхбаатар аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран эрх нь түр хугацаагаар хязгаарлагдсан иргэдэд Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг ял эдэлж байгаа иргэдэд сар бүр зохион байгуулж байна. 3. “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалт” аяны хүрээнд Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалт”, “Улаан бурхан өвчний шинж тэмдэг” сургалтуудыг зохион байгуулсан. Нийт 30 иргэн хамрагдсан. 4. “Насан туршдаа суралцацгаая - тантай хамт” арга хэмжээг Мөнххаан, Дарьганга, Түвшинширээ, Уулбаян сумдад зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд: “Цахимаар нэгдье” хөтөлбөрийн танилцуулга”, “Угийн бичиг хөтлөх арга зүй” насанд хүрэгчдэд зориулсан мэдээлэл технологийн боловсрол “Цахим шуудан, түүний хэрэглээ” дадлага, үйл ажиллагааг зохион байгуулж 238 иргэн хамрагдсан.	

		5. Зүүн бүсийн Насан туршийн суралцахуйн төвүүдийн “Багш солилцоо” арга хэмжээний хүрээнд Хэнтий аймгийн НТСТ-н гоо зүйн багш, Боловсролын ухааны докторант Д.Амартүвшин багш “Нүүрний хэлбэр, үсний онцлог шинжийн талаарх онолын ойлголт, Гоо сайхны бүтээгдэхүүний хэрэглээ, Эрэгтэй эмэгтэй үс засалт, үсний арчилгаа, имиж бүрдүүлэлт” сэдвээр сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажилласан. 6. “Насан туршийн суралцахуйн төвийн хамтын ажиллагаа, туршлага солилцох үйл ажиллагаа 2025” арга хэмжээний хүрээнд Багануур дүүргийн НТСТ-ийн захирал А. Өсөхжаргалыг урьж хамтран ажилласан. Захирал А.Өсөхжаргал нь салбарын шинэчлэл хамтын ажиллагаа, тэргүүн туршлага чиглэлээр өөрийн байгууллагын туршлагыг түгээн дэлгэрүүлж, хойшид хамтран ажиллах талаар шийдвэрлэлээ. 7. Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн түүхт 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “Эрдэм шинжилгээний хурал”-ийг хамтран зохион байгуулсан. Уг хуралд 10 гаруй эрдэмтэн докторууд оролцсон. 8. 2019 - 2025 онуудад ЯХИС-аас хэрэгжүүлсэн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хаалтын семинарыг төслийн багтай хамтран зохион байгуулсан. 9. Боловсролын яам, Насан туршийн суралцахуйн хэлтсээс хэрэгжүүлж буй “Малчин өрхийн гишүүний боловсрол, сургалтыг дэмжих” арга хэмжээний хүрээнд Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургууль дээр зохион байгуулагдаж буй “Мал аж ахуй эрхлэх ур чадвар олгох” 30 хоногийн түр сургалтад хамрагдаж буй малчин залуустай уулзаж байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулагдаж буй сургалтуудын талаар мэдээлэл өгч хамтран ажилласан.	
--	--	---	--